



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО



**Мэдээлэл, харилцаа холбооны салбарын зохицуулалт
ба мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа**

Г.ОЮУНЦЭЦЭГ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч

2014.05.27



Агуулга

1. МХХ-ны салбарын зохицуулалт
 - МХХ-ны салбарын зохицуулалтын ерөнхий байдал
 - Бие даасан, үр өгөөжтэй зохицуулах байгууллага байх логик үндэслэл
 - МХХ-ны салбарын зохицуулах байгууллагын үүрэг роль юунд орших вэ?
2. МХХ-ны салбар дахь хяналт шалгалт, шинжилгээ
 - МХХ-ны салбарт хийгддэг хяналт, шалгалт
 - МХХ-ны салбарт хийгддэг хяналт шинжилгээ/ мониторинг/
3. ХХЗХорооны 2013 онд хийсэн гол ажлууд
4. ХХЗХорооны 2014 оны гол зорилтууд



1.МХХ-ны салбарын зохицуулалт

МХХ-ны салбарын зохицуулалтын ерөнхий байдал

1.1. Шинэ нэр томъёо, шинэ зохицуулалт

блог,гууглэдэх, вэб 2.0,википедия,MP3,SMS,VoIP,WiMAX,IP,LTE

1.2. Мэдээллийн технологи, өөрчлөлтөнд зориулсан боломжууд ба эрсдлүүд

МТ-ийн хөгжлийн олон боломжууд нь зохицуулах байгууллагаас мэдээллийн нууцыг хамгаалах, хүүхдийг онлайн орчинд хамгаалах, хувийн бүртгэлийн кодыг ашиглан хулгай хийх зэрэг кибер гэмт хэргээс урьдчлан сэргийлэх зэрэг хэд хэдэн салбарт шинэ хууль боловсруулахыг шаардаж байна.Хэвлэл мэдээллийн салбар, банк санхүүгийн салбар, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл салбар зэрэг нь МХХ-ны зохиулалтын эрхзүйн зохицуулалтанд өртөхөөс өөр аргагүй байдалд хүрэх болсон.

Төр засгаас хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ бүх талуудын хууль ёсны ашиг сонирхлыг, тэр тусмаа хэрэглэгчийн эрхийг хамгаалсан технологийн өргөнөөр нэвтрүүлэх шаардлага урган гарах болсон.



1.МХХ-ны салбарын зохицуулалт

МХХ-ны салбарын зохицуулалтын ерөнхий байдал

Зохицуулагчийн хувьд хуулийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг бий болгоход технологийн хөгжлийн зэрэгцээ технологиос хамааралтай /халдлагад өртөмтгий/ байдлыг ашиглагчдаас нийгмийг хамгаалах явдлыг хангах хэрэгтэй болсон. Үүний тулд яаралтай тусламжийн албыг бий болгох, мэдээллийг хууль ёсоор авах /тел. яриаг сонсох г.м/

1.3. Дараа үеийн сүлжээ рүү шилжих

1.4. Инновацийн технологиуд ба үйлчилгээнүүд

Уламжлалт зах зээлийн тоглогчийн үйлчилгээг өөр тоглогч өөр технологиор үзүүлэхдээ тогтоомын дүрэм нь өөр байдаг./VoIP,IPTV,You tube,Apple's iPhone App Store г.м/

1.5. Бид үүн рүү хэрхэн ирсэн бэ?

Төлөвлөгөөт нийгмийн үеийн Холбооны Яам, Зах зээлийн либералчлал, Зохицуулах байгууллага бий болсон, хувьчлал, конвергенцлэгдсэн үеийн зохицуулах байгууллага



1.МХХ-ны салбарын зохицуулалт

МХХ-ны салбарын зохицуулалтын ерөнхий байдал

1.6. Зохицуулах үйл ажиллагааны дэс дараалал

Зах зээлийг өрсөлдөөнд нээлттэй болгосны дараагийн алхам нь холбогдох хууль эрхзүйн орчныг өөрчлөх, энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэгч байгууллагыг байгуулах үйл ажиллагаа байдаг ч эдгээрийг хийхээр тогтоосон энгийн дараалал байдаггүй.

Учир нь хэдэн хэдэн ажлыг нэгэн зэрэг хийж эхлэх шаардлага гардаг. Харилцан холболт, БНҮҮ, Зохицуулалтыг хэрэгжүүлэх, маргаан шийдвэрлэх, зах зээлийг тодорхойлох, зөвшөөрөл, лицензийг олгох, түүнчлэн тарифыг тогтоох зарчмуудтай холбоотой асуудал нь харьцангуй шахуу хугацаанд шийдвэрлэгддэг. Эдгээрээс ихэнх асуудал нь зохицуулалтын нөхцлийн өөр бүрэлдүүлэгчтэй харилцан холбоотой , тэдгээрт суурилсан эсхүл тэдгээрт хамаатай байдаг.

Энэ хамаарал нь технологийн дэвшил ба зах зээлийн хөгжлийг тооцсон тохиолдолд л өөрчлөгддөг.



1.МХХ-ны салбарын зохицуулалт

Бие даасан, үр өгөөжтэй зохицуулах байгууллага байх логик үндэслэл

Либералчлагдсан зах зээлд тоглогчдын хувьд үл ялгаварлах горимыг хангах нь бие даасан зохицуулах байгууллагыг байгуулах нь зайлшгүй логик үндэслэл болсон.

Үл ялгаварлах үндсэн нөхцөл нь:

- Зах зээл дэх тэнцвэртэй бус бүтцэнд тоглогчид нь тоглолтын нэгдсэн талбайд /дүрэм/ өрсөлдөөний нөхцөлд хамтрах боломжийг бий болгох
- Зах зээлд нийлүүлэх тоног төхөөрөмжийг нийлүүлэгчид адил горим үйлчилдэг байх
- Зах зээлд шинээр оролцогч болон хөрөнгө оруулагчдад давамгайлагчийн зүгээс үндсэн нөөц /тухайлбал, харилцан холболт/-ийг нийлүүлэхдээ нэг ижил горим /нөхцөл/ -ыг хэрэглэдэг байх
- Үйлчлүүлэгч бүх талуудын дуу хоолой, тэдний гомдол ба сонирхлуудыг зохих ёсоор нь тооцсон байх



1.МХХ-ны салбарын зохицуулалт

МХХ-ны салбарын зохицуулах байгууллагын үүрэг роль юунд орших вэ?

ДХБ-ын тодорхойлсон 7 зүйлийн хүрээнд орчин цагийн зохицуулах байгууллагын үндсэн үүргийг дараах байдлаар тодорхойлдог.

1. МХХ-ны салбарт шинээр хөрөнгө оруулагчид болон компаниудын бизнесийн үйл ажиллагааг явуулах боломжийг хангасан зөвшөөрөл олголтыг нэвтрүүлэх
2. Зах зээл дээр шинэ тоглогчдод нэгдсэн тоглолтын талбар бий болгох, давамгайлагч нийлүүлэгчийн эрхийг хязгаарлах, шударга, үр өгөөжтэй өрсөлдөөнийг бий болгох зэрэг өрсөлдөөнийг зохицуулалтыг хийх /тарифыг оролцуулан/
3. Сүлжээ ба хэрэгслийн харилцан холболт: уламжлалт сүлжээ ба шинэ сүлжээний харилцан холбогдох дүрэм, тэдгээртэй холбоотой зардалд суурилсан төлбөрийг ил тод болгох
4. МХХ-ны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн үүрэгт үйлчилгээний механизмыг нэвтрүүлэх
5. Шинэ технологийн нэвтрэлт тухайлбал, өргөн зурвасын холболтын нэвтрэлт, шинээр зах зээлд оролцогчдыг дэмжихийн тулд радио давтамжийн зурвасын ашиглалтыг үр өгөөжтэй удирдах
6. Нууцын зэрэглэлтэй мэдээлэл алдах, кибер гэмт хэрэг, шударга бус бизнес эрхлэлт зэргээс хэрэглэгчдийг ялангуяа хүүхдийг хамгаалах хангалттай баталгааг бий болгох
7. Зохицуулалт болон гэрээг хэрэгжүүлэлттэй холбоотой өртөг зардлыг хамгийн бага хэмжээнд хүргэх www.wto.org



2. МХХ-ны салбар дахь хяналт шалгалт, шинжилгээ

2.1. МХХ-ны салбарт хийгддэг хяналт, шалгалт

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд МХХ-ны салбарын хяналт шалгалтыг Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд явуулдаг.

Ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжснээр мэдээлэл харилцаа холбооны салбар хамгийн анх зах зээлээ зохицуулалттайгаар либералчилж эхэлснээр тус салбарт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа идэвхитэй хөгжиж МХХ –ны салбар бусад салбартай харьцуулахад өрсөлдөөний эрүүл ,саруул орчинд хөгжиж түүний үр шимийг хэрэглэгчид хүртэж байгаа.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын зах зээл зохицуулалттай хэдий ч нээлттэй болсон энэ үед төрөөс бүх зүйлийг хянах боломжгүй юм.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь өөрт хуулиар олгогдсон эрхийн хүрээнд дараах хяналтуудыг хийдэг.

- тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэнд хяналт тавих/ ХХ- ны тухай хуулийн 9.1.2 заалт/
- зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах/ мөн хуулийн 9.1.5 заалт/



2. МХХ-ны салбар дахь хяналт шалгалт, шинжилгээ

2.1. МХХ-ны салбарт хийгддэг хяналт, шалгалт

- радио давтамжийн зурвасыг хуваарилах, хяналт тавих/ мөн хуулийн 9.1.10 заалт/
- радио долгионы тухай хууль, тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих / Радио долгионы тухай хуулийн 20-р заалт/

Эдгээр хяналтыг Харилцаа Холбооны тухай хуулийн 8.7 заалтын дагуу томилогдсон хяналтын байцаагчид, хорооны мэргэжилтнүүд, ИТА-наас бүрдсэн баг хийж ажлаа Даргын зөвлөл болон хорооны хуралд тайлагнаж цахим хуудсаар үр дүнг мэдээлж ажилладаг.

<http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=77>

Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоолоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд **дотоод хяналт шалгалт** явуулах нийтлэг журам батлагдсан нь хяналтын тогтолцооны нэг том бүрэлдэхүүнийг бий болох эрх зүйн орчинг бүрдүүлсэн болно.



2.МХХ-ны салбар дахь хяналт, шинжилгээ

2.2 МХХ-ны салбарт хийгддэг хяналт шинжилгээ/ мониторинг/

Конвергенц(ижилсэн нэгдэлт)-лэгдэж буй мэдээлэл харилцаа холбооны зах зээлийн орчинд зохицуулах байгууллагуудад тулгарч буй томоохон сорилт нь технологийн хувьд нейтрал зохицуулалтыг хийх асуудал юм.

Өнөөгийн байдлаар тус хорооноос гаргасан зохицуулалтын баримт бичгийн хүрээнд телевизийн ӨН-ийн нөхцөл шаардлагын биелэлтэнд хөндлөнгийн байгууллагаар хяналт хийлгэн Даргын зөвлөл болон хорооны хуралд тайлагнаж зөрчлийг арилгуулах хэмжээг авч ажиллаж байгаа нь зохих үр дүнгээ өгч эхэлсэн. Дараах линкээр хяналт шинжилгээ/ мониторингийн тайлангуудтай танилцаж болно.
<http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=77>

Зохицуулах хорооны хувьд өргөн нэвтрүүлэг болон контентийн зохицуулалтыг хийж эхэлсэн ч зохицуулалтын эрх зүйн орчныг нь тодорхой болгох шаардлага урган гарч энэ тал дээр төр засгаас анхаарал тавьж хуулийн төсөл боловсруулах ажил хийгдэж эхэлсэн.

Бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлт

1. Дотоод үйл ажиллагааны процесс шинжилгээ, загварчлал хийсэн, дотоод хяналтын тогтолцоог шинээр бүрдүүлсэн.
2. Цахим-ХХЗХ (e-CRC) төслийн эхний үе шатыг хэрэгжүүлж үйлчилгээ, мэдээллийн хэсгийг байгуулан анхан шатны мэдээлэл, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг нэг цэгээс өгч ажиллах болсон.
3. Тусгай зөвшөөрлийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, ил тод зарчимд шилжүүлэх зорилгоор тусгай зөвшөөрөл шинээр хүсэх, хугацаааг сунгах хүсэлтийн маягтуудыг зааврын хамт он-лайн хэлбэрт шилжүүлэн туршсан.
<http://crc.gov.mn/main.php?cid=1&do=10>
4. Зохицуулалт, шинэ технологи чиглэлээр сургалт, семинар, уулзалт, хэлэлцүүлгийг 20 гаруй удаа зохион байгуулсан.

Зохицуулалтын орчныг шинэчлэх, радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалт

1. Зохицуулалтын чиглэл, журам, нөхцөл шаардлагын шинжилгээ, шинэчлэлт (70): шинээр буюу шинэчилсэн-39, нэмэлт өөрчлөлт-7, 36 хүчингүй болгосон.
2. Радио давтамжийн суурин хяналтын шинэчлэлт
3. Тоон өргөн нэвтрүүлэг, Радио тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын стандарт, баримт бичиг (10 үндэсний стандарт, 11 багц баримт бичиг)
4. Тоон өргөн нэвтрүүлэгт шилжих үндэсний хөтөлбөр-2013 зорилтууд
5. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, 21 аймгийн сумдад хийсэн.



4. ХХЗХорооны 2014 оны гол зорилтууд

Хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын шинэчлэлт

1. “Салбарын талаар 2021 он хүртэл Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг”-ийг боловсруулах
2. Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Цахим гарын үсгийн тухай зэрэг\ тогтоомжийг шинэчилэх, нэмэлт өөрчлөлт оруулах
3. Өргөн нэвтрүүлгийн тухай, Өгөгдөл хамгаалах тухай, Мэдээллийн технологийн тухай багц хууль төслүүдийг шинээр боловсруулах
4. Шинэ хуульд нийцүүлэн зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлага, холбогдох баримт бичгүүдийг шинэчлэх



4.ХХЗХорооны 2014 оны гол зорилтууд

Зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, шинэ үйлчилгээ технологи нэвтрүүлэх

1. Салбарын тусгай зөвшөөрлийн үйлчилгээг он-лайн хэлбэрт бүрэн шилжүүлэн хэрэгжүүлэх
2. Дотоод үйл ажиллагааг дэмжих нэгдсэн программ нэвтрүүлэх
3. Радио тоног төхөөрөмжийн итгэмжлэгдсэн баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх
4. Шинэ үйлчилгээ, техник технологийн ололтыг \LTE, Number portability, National rouming\ нэвтрүүлэхдээ өрсөлдөөн, зах зээлийн багтаамж, холбогдох судалгааны үндсэн дээр зохицуулалтын орчинг бүрдүүлэн хэрэгжүүлэх



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

Анхаарал тавьсанд баярлалаа.

e-mail: goyun@crc.gov.mn